



2020 оны 12 дугаар сарын 04
№45 /1147/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

479. Хэлэлцээр соёрхон батлах тухай 2343

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

480. Төрөөс мөнгөний бодлогын талаар
2021 онд баримтлах үндсэн чиглэл
батлах тухай Дугаар 32 2345

481. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны
09 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 35 2353

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

482. Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай Дугаар 127 2355

483. Шүүгчийн албан тушаалд
шилжүүлэн томилох тухай Дугаар 128 2355

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

484. Журам батлах тухай Дугаар 228 2356

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

485. Европын хөгжлийн сан болон
Европын холбооны нэгдсэн төсвөөс
санхүүжих төслүүдэд үйлчлэх Монгол
Улсын татварын болон гаалийн
зохицуулалтын тухай ерөнхий хэлэлцээр 2361



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар болон Европын Холбоо хооронд 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан “Европын хөгжлийн сан болон Европын Холбооны нэгдсэн төсвөөс санхүүжих төслүүдэд үйлчлэх Монгол Улсын татварын болон гаалийн зохицуулалтын тухай ерөнхий хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд хууль, эрх зүйн орчныг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын зөвлөмжтэй нийцүүлэн боловсронгуй болгох, Монгол Улсын үнэлгээний үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, үндэсний хөтөлбөрийг батлах;

2/санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, санхүүгийн маргааныг олон улсын шилдэг туршлагад үндэслэн шийдвэрлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

3/санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах;

4/банкны салбарын актив хөрөнгийг ангилж, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах эрх зүйн зохицуулалтыг олон улсын шилдэг туршлага, зөвлөмж, Монгол Улсын банкны салбарын онцлогт тулгуурлан боловсронгуй болгож, үе шаттайгаар мөрдүүлэх;

5/банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлэх;



6/олон улсын шилдэг туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;

7/Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах;

8/цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийн үед импортыг орлох, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
32 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1.Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2021-2023 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна.

1.2.Банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3.Төв банкны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах зорилгоор олон нийтийг мэдээллээр хангаж ажиллана.

2.Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1.Санхүүгийн мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарт учирч болзошгүй сөрөг нөлөөг бууруулж, банкны эрсдэл даах чадварыг хадгална.

2.2.Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн сайжруулж, банкны хяналт шалгалт, зохицуулалтын орчныг боловсронгуй болгоно.

2.3.Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ.

3.Санхүүгийн захын дэд бүтцийг хөгжүүлэх хүрээнд:

3.1.Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлнэ.

3.3.Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.



Үсгэнэмгэ бичигэр мэр гэрлэ үсгэнэмгэ мэр гэрлэ үсгэнэмгэ

Монгол Улсын Засаг Зарга

Монгол Улсын Засаг Зарга

2020 он 06 сар 06 өдөр болон 06 сар 07 өдөр

Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга
Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга

Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга
Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга

Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга
Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга

Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга
Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга

Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга
Монгол Улсын Засаг Зарга болон Монгол Улсын Засаг Зарга

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 11 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс ... эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Үсчинг үзвэл үзвэл үзвэл үзвэл үзвэл

МОНГОЛЫН УЛАС

Культур

Улаанбаатар 2020 - 2021 - 2022

МОНГОЛЫН УЛАСЫН ХУУЛЬ ГАРГАХ АНГЫН ХУУЛЬ

МОНГОЛЫН УЛАСЫН ХУУЛЬ ГАРГАХ АНГЫН ХУУЛЬ
2020 - 2021 - 2022

6. Үсчинг үзвэл үзвэл үзвэл үзвэл үзвэл
МОНГОЛЫН УЛАСЫН ХУУЛЬ ГАРГАХ АНГЫН ХУУЛЬ
2020 - 2021 - 2022

МОНГОЛЫН УЛАС
Улаанбаатар

№ 45 /1147/

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 10 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн шүүгч Сэмжидийн Нолхоосүрэнг Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 10 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 128

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Сайнбаярын Оюунжаргалыг Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Бат-Эрдэнийн Батчимэгийг Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжин томилогдох болсонтой холбогдуулан шүүгч Сайнбаярын Оюунжаргалыг Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Бат-Эрдэнийн Батчимэгийг Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 228

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2020 оны
228 дугаар тогтоолын хавсралт

ОЮУТНЫ ЦАГААР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь оюутан сайн дурын үндсэн дээр хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэн ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, дадлагажих, төгсөөд шууд ажлын байртай болох, орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2.Оюутныг хувийн хэвшлийн байгууллага (100 ба түүнээс дээш ажилтантай)-д цагаар хөдөлмөр эрхлүүлэх, түүнтэй холбоотой үүссэн харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3.“Оюутан” гэж их сургууль, дээд сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд суралцагчийг ойлгоно.

Хоёр. Оюутан цагаар хөдөлмөр эрхлэх зохицуулалт

2.1.Хувийн хэвшлийн байгууллага (100 ба түүнээс дээш ажилтантай) нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц цагийн ажлын орон тоо гаргаж, оюутныг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.

2.2.Оюутны цагийн ажлын үргэлжлэх хугацаа нь түүний сурч боловсрол нөхцөлийг хязгаарлахааргүй байна. Ажлын цагийн хязгаарлалт нь их, дээд сургууль, коллежийн оюутны улирлын амралтын хугацаанд хамаарахгүй.

2.3.Хувийн хэвшлийн байгууллага нь оюутантай цагийн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд хөдөлмөрийн гэрээнд гүйцэтгэх ажил үүрэг, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлсийг оюутны суралцах, ажиллах цагийн харьцаа, хийх ажлын чанар хэмжээг харгалзан талууд харилцан тохиролцож тусгана.

2.4.Мэргэжлийн чиг баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 15 нас хүрсэн оюутантай эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж, эрүүл мэнд, өсөлт хөгжилд нь сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход нь саад учруулахгүй нөхцөлд цагийн ажил эрхлүүлж болно.

2.5.Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэхийг оюутнаас шаардахыг хориглоно.

2.6.Залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 100 ба түүнээс дээш ажилтантай хувийн хэвшлийн байгууллагын жагсаалтыг жил бүрийн I улиралд шинэчлэн гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.7.Хувийн хэвшлийн байгууллага нь сул, чөлөөтэй цагийн ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр нь харьяалах аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага, хөдөлмөрийн биржид хүргүүлнэ.

2.8.Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага нь энэ журмын 2.7-д заасан мэдээллийг нэгтгэн, хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулж, их, дээд сургууль, коллежийн дэргэдэх Оюутны хөдөлмөр эрхлэх төвүүдийг холбогдох мэдээллээр хангана.

2.9.Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь цагийн ажлын байрыг оюутнуудад нээлттэй танилцуулж, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй оюутнуудын бүртгэл хөтөлнө.

2.10.Хөдөлмөрийн хувийн бирж болон холбогдох байгууллагууд оюутныг цагийн ажилд зуучлахтай холбоотой мэдээллийг залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн санд хүргүүлж, оюутныг цагийн хөдөлмөр эрхлэлтэд зуучилна.



2.11.Хувийн хэвшлийн байгууллага нь оюутныг сул, чөлөөтэй ажлын байранд цагийн ажилд авсан тухай тухайн оюутны суралцаж байгаа их, дээд сургууль, коллежийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд мэдэгдэнэ.

2.12.Хувийн хэвшлийн байгууллага, оюутны хооронд ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой үүссэн хөдөлмөрийн маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1.Хөдөлмөр, хүн ам, нийгмийн хамгааллын болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл нь оюутныг цагийн хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой бодлого, арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангана.

3.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлнэ.

3.3.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс жил бүр баталсан оюутны цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний санхүүжилтийн хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

3.4.Хөдөлмөр эрхлэлтийн болон залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

3.5.Аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургууль, коллежууд оюутныг цагаар хөдөлмөр эрхлэхийг дэмжих, орлого олох, хөдөлмөрийн харилцааны соёлд суралцах, ажлын байранд бэлтгэгдэх, эзэмшиж байгаа мэргэжлээрээ дадлагажих, мэргэших, төгсөөд ажилтай болох боломжийг өргөжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

3.6.Хувийн хэвшлийн байгууллага оюутны цагаар хөдөлмөр эрхлэх харилцаанд дараах үүрэгтэй:

3.6.1.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.9-д заасны дагуу оюутныг цагийн ажлын байраар хангах арга хэмжээ авах;

3.6.2.оюутныг цагаар ажиллуулах боломжтой ажлын байрыг урьдчилан тодорхойлж, орон тоо, ажлын байрны талаарх мэдээллийг



аймаг, нийслэл, дүүргийн залуучуудын болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн байгууллага, Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд улирал тутамд хүргүүлэх;

3.6.3.оюутныг тухайн суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээр нь нэн тэргүүнд ажиллуулах зарчим баримтлах;

3.6.4.оюутны гүйцэтгэх ажлыг үндсэн ажилтны гүйцэтгэж байгаа ажил, үүргээс илүүгүй байхаар тодорхойлох;

3.6.5.оюутантай харилцан тохиролцсоны үндсэн дээр хөдөлмөр эрхлүүлсний цалин хөлсийг нэг сар хүртэлх хугацаанд ажилласан өдөр бүр, түүнээс дээш хугацаагаар ажиллах бол сард хоёр удаа олгох;

3.6.6.оюутныг хөдөлмөр эрхэлсэнтэй холбоотой ажлын түүх үүсгэж, цагийн ажлын дэвтэрт тухай бүр тэмдэглэгээ хийх;

3.6.7.хөдөлмөрийн дотоод журамд оюутнаар цагийн хөдөлмөр эрхлэхтэй холбогдох зохицуулалтыг тусгаж, дотоод журмыг оюутанд танилцуулах;

3.6.8.ажил олгогч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

3.6.9.оюутан цагаар хөдөлмөр эрхлэх явцад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн болон эдгээр шалтгаанаар нас барсан тохиолдолд нөхөн төлбөрийг ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хариуцах;

3.6.10.хөдөлмөр эрхэлж байгаа оюутанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулж, үндсэн ажилтны нэгэн адил хамгаалах.

3.7.Оюутны цагийн хөдөлмөр эрхлэх асуудлаар өмчийн хэлбэрийг үл харгалзан их, дээд сургууль, коллеж нь дараах үүрэгтэй:

3.7.1.оюутныг хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрт бэлтгэгдэх, дадлага, туршлагатай болоход дэмжлэг үзүүлэх;

3.7.2.оюутныг цагийн ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, төсөл хөтөлбөр боловсруулах арга зүйд суралцуулах чиглэлээр жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;



3.7.3.оюутныг цагийн ажилд бүртгэх, хөдөлмөр эрхлэхэд зуучлах, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.7.4.холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлтэй холбоотой мэдээллийг ажиллахаар сонгогдсон оюутанд танилцуулж, зөвлөгөө өгөх;

3.7.5.цагаар хөдөлмөр эрхлэхтэй холбоотой өдөрлөг, арга хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн болон залуучуудын асуудал хариуцсан байгууллага, ажил олгогчидтой хамтран жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулах.

3.8.Цагаар хөдөлмөр эрхлэх оюутан дараах эрх, үүрэгтэй:

3.8.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, хийж гүйцэтгэсэн ажилдаа тохирсон цалин хөлс авах;

3.8.2.ажил олгогчоос өгсөн чиглэлийн дагуу ажил, үүргийг чанартай гүйцэтгэх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил, үүрэгтэй нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг шаардлага, дотоод журмыг биелүүлэх.

Дөрөв. Бусад

4.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЕВРОПЫН ХӨГЖЛИЙН САН БОЛОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ НЭГДСЭН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ТӨСЛҮҮДЭД ҮЙЛЧЛЭХ МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН БОЛОН ГААЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Нэг талаас Европын Комиссоор төлөөлүүлсэн Европын Холбоо (цаашид “Комисс” гэх)

Нөгөө талаас Монгол Улсын Сангийн ямаар төлөөлүүлсэн Монгол Улсын Засгийн газар (цаашид “Түншлэгч орон”, хамтад нь “Талууд” гэх) нар дараах зүйлийг тохиролцов:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийн зорилго нь Европын Холбооны нэгдсэн төсвөөс бүхэлдээ эсхүл тодорхой хэсэг нь санхүүжих төслүүдэд (цаашид “Төслүүд” гэх) үйлчлэх Түншлэгч орны татварын болон гаалийн зохицуулалтыг тодорхойлоход оршино. Энэхүү хэлэлцээр нь дараах нөхцөлийн хүрээнд зохих журмын дагуу тодорхойлогдоно:

- Европын Холбооны нэгдсэн төсвөөс санхүүжих төслүүдийн хувьд хөгжлийн төсөл хөтөлбөрүүдтэй холбоотойгоор Түншлэгч орноос бусад орон, олон улсын байгууллагад ногдуулдаг нэн тааламжтай гаалийн тариф, татварын нөхцөл байна.
- Түншлэгч орон дээр дурдсан хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд хэрэглэгдэх нэн тааламжтай татвар, гаалийн нөхцөл болон томоохон өөрчлөлтүүдийн тухай Европын Комисст жил бүр мэдээлж байхаар тохиров.
- Илүү тааламжтай гэрээний нөхцөл байхгүй тохиолдолд хөгжлийн төсөл хөтөлбөрүүдэд үйлчлэх боломжтой Түншлэгч орны үндэсний нэн тааламжтай хууль тогтоомж.

2 ДУГААР ЗҮЙЛ – ЦАР ХҮРЭЭ

1) Татвар болон гаалийн зохицуулалт нь Европын Холбооны нэгдсэн төсвөөс бүхэлдээ эсхүл хэсэгчилсэн санхүүжилтээр Түншлэгч оронд хэрэгжих бүх төслүүдэд үйлчлэх ба гэрээлэгч тал хэн байхаас үл хамааран энэхүү зохицуулалт нь Европын Холбооны нэгдсэн төсвөөс санхүүжиж байгаа төслийн бүх гэрээлэгч, тусламж хүлээн авагч, туслан гүйцэтгэгч, түншлэгч, харилцан хамаарал бүхий этгээд болон тусламжийг дамжуулан хүртэж буй этгээдүүдэд мөн хамаарна. Гэрээлэгч тал гэдэгт дараах этгээд хамаарч болно:

- төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч;
- тусламжийн хүрээнд хэрэгжих төслийг хэрэгжүүлэх зорилгоор гэрээнд гарын үсэг зурсан тусламж хүлээн авагч;
- хувь оруулах тухай хэлэлцээр эсхүл тусламж олгох тухай гэрээнд гарын үсэг зурсан олон улсын байгууллага;
- Европын Комисс, эсхүл
- Европын Комиссыг төлөөлөх эрх бүхий этгээд.

- 2) Түншлэгч орны байгуулсан хоёр талын болон олон талт аливаа хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол ашиг болон орлогын татварт энэхүү Ерөнхий хэлэлцээр үйлчлэхгүй болно.

3 ДУГААР ЗҮЙЛ - НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР

Европын Холбооны нэгдсэн төсвийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөлтэй холбоотой үйл ажиллагаа нь зарчмын хувьд Түншлэгч орны нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад ижил төрлийн татвараас чөлөөлөгдөнө.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТАТВАР БОЛОН ИМПОРТЫН ГААЛИЙН ТАТВАР

Европын Холбооны нэгдсэн төсвийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн үйл ажиллагаанд үйлчлэх Түншлэгч орны импортод ногдуулдаг бүх төрлийн татвар, гаалийн хураамжаас чөлөөлөгдөнө. Үүнд:

- Ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэх зорилгоор эд зүйл импортолж буй компанид Түншлэгч орны дотоодын хууль тогтоомжийн дагуу барааг түр хугацаанд нэвтрүүлэх горимыг хэрэглэх үүргээс хүсэлт гаргаснаар чөлөөлөгдөнө;
- Нийлүүлэлтийн гэрээний хүрээнд импортолж байгаа бараа, бүтээгдэхүүнд ногдуулах импортын гаалийн татвар, хураамж болон бусад захиргааны төлбөр, хураамжаас чөлөөлөгдөнө.
- Үйлчилгээний гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай бүх мэргэжлийн тоног төхөөрөмжийг түр хугацаанд нэвтрүүлэхэд импортын гаалийн татвар, хураамж болон бусад ижил төрлийн төлбөрөөс чөлөөлөгдөх ба энэ нь үзүүлсэн үйлчилгээний төлбөр болох үндэслэл болохгүй.
- Үйлчилгээний гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэхэд оролцох дотоодын ажилтнаас бусад ажилтан, хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн хувийн болон ахуйн хэрэглээний эд хэрэгсэлд үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу ногдуулах гаалийн татвар, хураамж болон ижил төрлийн бусад төлбөрийг чөлөөлнө.

5 ДУГААР ЗҮЙЛ – УЛСЫН ТЭМДЭГТИЙН БОЛОН БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ

Өмнө нь байсан эсхүл ирээдүйд бий болох аливаа улсын тэмдэгтийн болон бүртгэлийн хураамж, эсхүл бусад төрлийн төлбөр, хураамж энэхүү хэлэлцээрт хамаарах гэрээнүүдэд ногдуулахгүй. Гэхдээ гэрээг Түншлэгч орны хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбогдуулан гарах төлбөрийг төлж болно.

6 ДУГААР ЗҮЙЛ – БУСАД ТАТВАР

Энэхүү Ерөнхий хэлэлцээрт тусгайлан өөрөөр заагаагүй бол Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаанд бусад татвар, ижил төрлийн төлбөр, хураамж ногдуулахгүй.

7 ДУГААР ЗҮЙЛ – НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Энэхүү Хэлэлцээрийн аливаа нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, нэмэлт байдлаар оруулна.

8 ДУГААР ЗҮЙЛ – МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Талууд энэхүү Ерөнхий хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Хэрэв холбогдох албан байгууллагууд Ерөнхий хэлэлцээрт заасан үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй, тогтоосон хугацаанд багтаж зөрчлийг арилгахад шаардлагатай алхмыг хийхгүй бол Комисс нь тус зөрчлийн нөлөөлж буй санхүүжилтийн хэлэлцээрийг зогсоох эсхүл цуцлах боломжтой.

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбоотой гарсан маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын хооронд гарсан маргааныг Түншлэгч орон болон Комисс хооронд зөвшилцөх замаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр арбитраар шийдвэрлэж болно.

Энэ тохиолдолд арбитраар шийдвэрлүүлэх хүсэлт гаргаснаас хойш гуч хоногийн дотор талууд арбитраар томилох болно. Томилж чадаагүй бол аль аль тал нь Арбитрын байнгын шүүх (ГААГ)-ийн Ерөнхий нарийн бичигт хандан хоёрдогч арбитраар томилох хүсэлт хүргүүлж болно. Хоёр талаас томилогдсон арбитраар нар өөрсдийн хуваарийн дагуу гуравдагч арбитраар 30 хоногийн дотор томилох болно. Томилж чадаагүй тохиолдолд аль аль тал нь Арбитрын байнгын шүүх (ГААГ)-ийн Ерөнхий нарийн бичигт хандан гуравдагч арбитраар томилох хүсэлт хүргүүлж болно.

Арбитраар өөрөөр шийдвэрлээгүй бол Арбитрын байнгын шүүхийн Олон улсын байгууллага болон улс орнуудын оролцоотой арбитраар ажиллагааны заавал мөрдөгдөх бус журамд заасны дагуу шийдвэрлэнэ. Арбитраар гурван сарын хугацаанд олонхын саналаар шийдвэр гаргана. Тал тус бүр арбитраар шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах үүрэг хүлээнэ.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ЗОГСООХ, ЦУЦЛАХ

Тал тус бүр харилцан зөвшилцсөний үндсэн дээр 6 (зургаа) сарын өмнө мэдэгдэл хүргүүлэн энэхүү Ерөнхий хэлэлцээрийг цуцалж болно.

Энэхүү Ерөнхий хэлэлцээрийг цуцалсан хэдий ч үүнийг хүчин төгөлдөр байх хугацаанд зурагдсан аливаа гэрээ болон түүнтэй холбоотой маргаанд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

10 ДУГААР ЗҮЙЛ - ХАЯГ

Ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа харилцаа, холбоог бичгээр үйлдэж, дараах хаяг руу илгээнэ:

Комисс

Европын Холбооноос Тайландын Хаант
Улсад суугаа төлөөлөгчийн газар
Атин Тауэр, 10 давхар
63 Уаерлэсийн зам, Лумпини
Патумван Бангкок 10330,
Тайландын Хаант Улс

Гэрээ эрх зүй, Аудитын хэсэг, Санхүүгийн асуудал хариуцсан дарга
Утас: +66 2 305 2600
Факс: +66 2 305 2799

Түншлэгч орон

Монгол Улсын Сангийн яам
Засгийн газрын II байр
Данзангийн гудамж 5/1
Улаанбаатар 15160, Монгол Улс

Хөгжлийн санхүүжилтийн газар
Факс: 976-51-267468

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай Монгол Улсаас илгээсэн мэдэгдлийг Комисс хүлээн авсан өдөр энэхүү Ерөнхий хэлэлцээр хүчин төгөлдөр болох ба энэ нь талууд тохиролцсоны үндсэн дээр хэлэлцээрийг урьдчилан хэрэглэх боломжийг хязгаарлахгүй.

Хэлэлцээрийг хоёр хувь үйлдэж, нэгийг Комисст, нөгөөг Монгол Улсад тус тус хүргүүлсэн нь адил хүчинтэй гэж тооцогдоно.

ТҮНШЛЭГЧ ОРНЫГ ТӨЛӨӨЛЖ

КОМИССЫГ ТӨЛӨӨЛЖ

ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР

ЖАН-ЛУИС ВИЛЛЕ

Монгол Улсын Сангийн сайд

Захирлын үүрэг гүйцэтгэгч

Ази, Төв Ази, Ойрхи дорнод,
Номхон далайн орнуудын
хэлтэс

Олон улсын хөгжил, хамтын
ажиллагааны газар

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003